



**Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхэдтэй
эцэг эхчүүдийн агаарын бохирдол бага насны
хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн
талаарх ойлголт хандлага**

/Судалгааны тайлан/





1. СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГАЧЛАЛ

1.1 Судалгааны загвар: Амьсгалах эрх төслийн хүрээнд Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн Агаарын бохирдол бага насны хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх мэдлэг, хамгаалах дадал, хандлагыг судлан тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэхдээ аналитик судалгааны агшингийн аргыг ашигласан.

1.2 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТИЙН ҮЕ ШАТ:

Улаанбаатар хотын 9 дүүргээс зорилтот түүврийн аргаар Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдийг сонгон авсан. Түүвэрлэлтийн 2-р үе шатанд сонгогдсон 5 дүүргийн 21 хороог сонгон авав./Зураг.1/



Зураг 1. Судалгаанд оролцогчдыг түүвэрлэсэн арга зүй.

1.3 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН ТООН БОЛОН ЧАНАРЫН АРГА





Эцэг эхчүүдээс авсан “Агаарын бохирдол бага насны хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөл нөлөөлөл”-ийн талаарх асуумж:

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдээс хаалттай, болон хагас нээлттэй асуулт бүхий нийт 12 асуулт бүхий урьдчилан бэлтгэсэн асуумжийн хуудсаар сургалтын өмнө мэдээллийг цуглуулав. (Хавсралт Асуумж нь дараах бүлгүүдийг багтаасан.

- Ерөнхий мэдээлэл /Дүүрэг, хороо/
- Агаарын бохирдолоос хувь хүн өөрийгөө хамгаалах арга
- Хүүхдээ агаарын бохирдолоос хамгаалах талаарх мэдлэг, хандлага

Эцэг эхчүүдтэй явуулсан бүлгийн ярилцлага

Бүлгийн ярилцлагыг хийхдээ хорооны оролцогчдыг санамсаргүй байдлаар бүлэгт хувиарлаж судалгааны багийн ахлагч ярилцлагыг чиглүүлж, тэмдэглэлийг давхар бичиж хөтөлсөн (Хавсралт 2). Ярилцлагын явцад яагаад, яаж асуултуудаар ярилцлагыг идэвхтэй аргаар оролцогч төвтэй явуулсан.

Эцэг эхчүүдтэй хийх бүлгийн ярилцлагын удирдамж

- Утаанаас хамгаалах авч буй арга хэмжээ
- Авч буй арга хэмжээнд гарж буй хүндрэл
- Тулгамдаж буй асуудалыг шийдэх арга замууд

Судалгааны статистик боловсруулалт

Судалгааны мэдээллийг SPSS 25.0 програм ашиглан, сургагдсан судлаачид тоон датаг оруулж, алдааг шалгасан. Статистик боловсруулалт хийхээс өмнө мэдээг цэвэрлэв. Судалгааны тоон мэдээллийг тоо, хувиар илэрхийлэв. Судалгааны чанарын мэдээллийг шигтгээ өгүүлбэрээр илэрхийлэв.

2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Судалгаанд сонгогдсон 5 дүүргийн 21 хорооны нийт 222 бага насны хүүхэдтэй эцэг, эх судалгаанд оролцсон.

Хүснэгт 1. Сонгогдсон хороодоос бага насны хүүхэдтэй судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд

Дүүрэг	Нийт тоо N(%)	Хороо	Судалгаанд оролцсон хүн ам
--------	------------------	-------	-------------------------------






		Тоо	Хувь	
		БД14	8	3.6
		БЗД15	7	3.2
		БЗД02	20	9.0
Баянзүрх дүүрэг	73 (32.9)	БЗД21	9	4.1
		БЗД24	21	9.5
		БЗД27	14	6.3
		БЗД04	2	0.9
Чингэлтэй дүүрэг	10(4.5)	ЧД10	6	2.7
		ЧД9	4	1.8
Хан-Уул дүүрэг	30 (13.5)	ХУД16	17	7.7
		ХУД5	5	2.3
		ХУД6	8	3.6
		СБД12	11	5.0
Сүхбаатар дүүрэг	50 (22.5)	СБД13	10	4.5
		СБД16	5	2.3
		СБД17	16	7.2
		СХД10	11	5.0
		СХД03	15	6.8
Сонгинохайрхан дүүрэг	59 (26.6)	СХД07	3	1.4
		СХД08	17	7.7
		СХД09	13	5.9
Нийт	(222)100.0		222	100.0

Нийт судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн харьяалалаар Баянзүрх дүүрэг 32.9%, Сонгинохайрхан дүүрэг 26.6%, Сүхбаатар дүүрэг 22.5%, Чингэлтэй дүүрэг 4.5%, Хан-Уул дүүрэг 13.5% эзэлж байв. /Хүснэгт1/


Зураг 1. Эцэг эхчүүдийн агаарын бохирдолоос хамгаалах маскны хэрэглээ





Судалгаанд хамрагдсан бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн дунд агаарын бохирдолоос хамгаалах маск 89(40.1%) нь огт зүүдэггүй, 111(50.0%) нь хааяа зүүдэг буюу тогтмол зүүж хэвшээгүй, 22(9.9%) нь тогтмол зүүдэг байна/Зураг1/.

Зураг 2. Эцэг эхчүүд бага насны хүүхдээ агаарын бохирдолоос хамгаалах маск зүүлгэх байдал



Эцэг эхчүүдийн бага насны хүүхэддээ маск зүүлгэх дадлыг үнэлэхэд судалгаанд хамрагдагсдын 41(18.5%) нь огт зүүлгэдэггүй, 112(50.5%) нь хааяа буюу тогтмол зүүлгэж хэвшээгүй, 68(30.6%) нь тогтмол зүүж өгдөг байна/Зураг2/.

Шигтгээ 1.
Утаанаас хамгаалах ямар арга хэмжээ авч байгаа вэ?






Ард иргэд бид зөвлөгөө бүхэнг биелүүлэх боломжгүй байдаг дор бүрээ л нөхцөл байдал, боломж бололцоондоо тохирсон энгийн аргуудыг хэрэглэж хүүхдээ өөрсдийгөө хамгаалж байна. Ард иргэдийн нийтлэг хэрэглэж буй арга:

- Маск зүүдэг
- Цэвэр агаарт гардаг
- Гэртээ чийгтэй цэвэрлэгээ хийдэг
- Аарц , чацаргана буцалгаж уудаг
- Сармистай ус саванд хийж тавьдаг
- Шаардлагагүй тохиолдолд гэртээ байдаг
- Дархлаа дэмждэг амин дэмтэй хоол хийж иддэг

Эх сурвалж: **Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас**


Зураг 3. Агаарын бохирдолоос хамгаалах маск хүүхэддээ зүүлгэдэггүй нийтлэг шалтгаан



Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн хүүхэддээ агаарын бохирдолын маск зүүлгэхгүй байгаа шалтгааныг тодруулахад 39.9 хувь нь хүүхэд амьсгалахад төвөгтэй, 32.9 хувь нь худалдаж авах боломжгүй, 42.3 хувь нь хүүхэд зүүх дургүй байдаг гэсэн хариултыг өгсөн/Зураг 3/. Тус судалгааны дүнгээс харахад бага насны хүүхэд агаарын бохирдолоос хамгаалах маск зүүхгүй байхад эцэг, эх нийгмийн болон санхүүгийн нөөц бололцоо, хувь хүүхэд өөрөө зүүж хэвшээгүй дургүй гэх мэт олон талт шалтгаан нөлөөлж байна.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын гэртээ агаар цэвэршүүлэгч хэрэглэх байдал





Нийт судалгаанд хамрагдагсдын 81.7 хувь нь гэртээ агаар цэвэршүүлэгч хэрэглэдэггүй, 18.3 хувь нь гэртээ агаар цэвэршүүлэгч хэрэглэдэг байна.

Шигтгээ 2.

Утаанаас өөрийгөө болон хүүхдээ хамгаалахад тулгамдаж буй **хүндрэлүүд** ?


Агаарын бохирдол их байгааг хүн бүхэн хараад, үнэрлээд мэдэрч байгаа хамгаалах аргуудын тухай мэдээллүүд авч л байна гэвч бидэнд тэдгээр аргыг хэрэглэхэд тодорхой асуудалууд тулгарч байна. Ард иргэдэд тулгамдаж буй асуудалууд:

- Мөнгө эдийн засаг
- Салхинд гарахад зав цаг хугацаа бага
- Маск зүүхэд таарамж муу байдаг
- Хүүхэд зүүхдээ дургүй байдаг
- Аньс, чацаргана, цагаан идээ үнэтэй чанар муутай
- Хямд маск зүүх нь нэмэр болдоггүй, маск цантдаг
- **Маскны ялгаа болон хор нөлөөг сайн мэддэггүй**
- Хичээл цэцэрлэг тарах цагт агаарын бохирдол бүр их байна. Хүүхдүүд энэ үед гадуур явж таардаг.

Эх сурвалж: Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Зураг 5. Агаар цэвэршүүлэгч хэрэглэхгүй байгаа шалтгаан, хувиар





Нийт судалгаанд оролцогчдын 114(64.0%) нь хэтэрхий үнэтэй, 10(5.6%) нь хэрэглэх аргыг мэдэхгүй, 10(5.6%) нь хаанаас авахаа мэдэхгүй байх нь агаар зэрэг нь үндсэн шалтгаан болж байна гэж үзсэн/Зураг 5/.

Шигтгээ 3.


Тулгамдаж буй асуудалыг шийдэх арга зам юу байж болох вэ? Магадгүй дараах асуудлуудыг шийдвэл бид энэ бэрхшээлүүдийг туулж агаарын бохирдолоос өөрсдийгөө хамгаалж чадах байх.

- Чанарын шаардлага хангасан маск иргэдэд хямд үнээр нийлүүлж хүргэх
- Орон сууцжуулах
- Цахилгаан хүчин чадал нэмэгдүүлэх, төлбөр хөнгөлөх
- Айл өрхийг агаар цэвэршүүлэгчээр хангах, авах нөхцөлийг бүрдүүлэх
- Утаа бага ялгаруулах түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх+
- Төрийн бодлого зохицуулалтаар шийдвэрлэх+

Эх сурвалж: Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Зураг 6.
Хүүхэд дам
тамхидалтанд
өртдөг эсэх





Нийт судалгаанд оролцсон бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн 27(12.4%) нь гэртээ тамхи татдаг, 190(87.6%) нь гэртээ тамхи татдаггүй байна. Бага насны хүүхэдтэй эцэг эх гэртээ тамхи татах нь гэрийн дотоод орчны бохирдолыг нэмэгдүүлдэг.

Хүснэгт 2. Хүүхдийн хөхөөр хоололтын байдал

Үзүүлэлт	Судалгаанд оролцогчид	
	Хувь /%/	Тоо /N/
Хөхөөр хоололтын байдал		
Хүүхэдээ хөхөөр хоололдог/хооллож байсан	84.7	171
Хүүхэдээ хөхөөр хоололдоггүй/хооллож байгаагүй	15.3	31

Нийт судалгаанд оролцогчдын 84.7% нь хүүхдээ хөхөөр хооллодог буюу хооллож байсан, 15.3 хувь хүүхдээ хөхөөр хооллож байгаагүй байна.

Хүснэгт 3. Хүүхдийн өвчлөл, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын байдлыг үнэлсэн дүн


Үзүүлэлт	Судалгаанд оролцогчид	
	Тоо /N/	Хувь /%/





Хүүхдийн сард ханиад хүрсэн тоо		
1 удаа	90	40.5
2 удаа	57	25.7
3 удаа ба түүнээс дээш	45	20.3
Хүүхэд ханиадын хүндрэсний улмаас эмнэлэгт хэвтсэн байдал		
Тийм	56	26.3
Үгүй	157	70.7
Хүүхэддээ ханиад, томуугаас сэргийлэх вакцин хийлгэсэн байдал		
Тийм	118	54.9
Үгүй	97	45.1

Зураг 7.5 хүртэлх насны хүүхдийг замын хажуугаар өргөж гарах дадал



Нийт судалгаанд оролцогчдын 75.5 хувь нь хүүхдийг замын хажуугаар өргөж явдаг бол, 24.5 хувь нь хүүхдийг замын хажуугаар өргөж явдаггүй гэж хариулжээ.

Хүснэгт 4. Ханиад хатгалгааны вакцин хийлгэсэн болон хийлгээгүй бүлэг хоорондын ялгаа

Ханиад, хатгааны вакцин хийлгэсэн бүлэг N/%/	Ханиад, хатгааны вакцин хийлгээгүй бүлэг N/%/	P утга





Хүүхдийн 1 сард ханиад хүрсэн давтамж

1 удаа	49/46.7/	40/46.5/	
2 удаа	30/28.6/	27/31.4/	0.015
3 удаа	26/24.8/	19/22.1/	
Нийт	105/100.0/	86/100.0/	

ДҮГНЭЛТ

- Судалгаанд нийт 5 дүүргийн 21 хорооны 5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдийг хамруулав.
- Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүд агаарын бохирдолоос хамгаалах маск 89(40.1%) нь огт зүүдэггүй, 111(50.0%) нь хааяа зүүдэг.
- Эцэг эхчүүдийн 41(18.5%) нь хүүхэддээ агаарын бохирдлын маск огт зүүлэгдэггүй, 112(50.5%) нь хааяа буюу тогтмол зүүлгэж хэвшээгүй.
- Хүүхдэд эцэг, эхчүүдийн агаарын бохирдолын маск зүүлгэхэд тулгарч буй гол асуудал нь худалдан авах чадвар байв.
- Нийт судалгаанд хамрагдагсдын 81.7 хувь нь гэртээ агаар цэвэршүүлэгч хэрэглэдэггүй. Иймд бага насны хүүхэд дотоод орчны агаарын бохирдолд өртөж буй юм. Агаар цэвэршүүлэгчийг хэрэглэхгүй байгаа гол шалтгаан нь үнийн асуудал байв/64.0%/.
- Ард, иргэд дор бүрээ агаарын бохирдлоос хамгаалах энгийн аргууд болох маск зүүх, цэвэр агаарт гарах, гэртээ чийгтэй цэвэрлэгээ хийх, аарц, чацаргана буцалгаж уух болон дархлаа дэмжих амин дэмтэй хоол идэх зэрэг хувь хүний түвшний хамгаалалтууд нийтлэг ашиглаж байв. Энэхүү хамгаалалтууд нь өртөг шаардсан, агаарын бохирдлоос хамгаалах механизмын нотолгоо шинжлэх ухаанаар батлагдаагүй болно. Тиймээс улсын хэмжээнд агаарын бохирдлоос хүн амыг нийтэд нь хамгаалах, агаарын бохирдлыг тэглэх томоохон, үр дүнтэй бодлого үгүйлэгдэж байна.

